



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/114/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 70523020 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
Аудитор: Т.Мөнхтогтох
Утас: 70523020 Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ДГА	Дорноговь аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.1.1	Илрүүлэлт:.....	12
3.1.2	Эрсдэл:	12
3.1.3	Өгсөн зөвлөмж:	12
3.2	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	12
3.2.1	Илрүүлэлт:.....	12
3.2.2	Эрсдэл:	13
3.2.3	Өгсөн зөвлөмж:	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.02.25 № 1-6/158

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.БЭЭЖИН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шүүхийн тамгын газрын даргад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 11-ээс 2019 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар нь Хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Прокурорын тухай хуулиар Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд “нийцсэн” байна.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийгдсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар 2018 оны Нийт зардал 1,022,407.6 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 10,224.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	11,259.5	Дараа сарын цалинг урьдчилж олгосон, гэрэл цахилгаан болон цэвэр бохир усны төлбөрийг нэхэмжлэхийн дүнгээр шилжүүлдэггүй.
2	Төлбөрийн акт тогтоосон	1	222.0	12 сард 2 хоногийн хоолны мөнгө илүү олгосон.
3	Албан шаардлага өгсөн	1	175.8	Ажлаас чөлөөлөгдсөн хүний ээлжийн амралтын тооцоо хийгээгүй.
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	5	11,657.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Илрүүлэлт. Балансын данстай холбоотой асуудал.

2018 оны 12 сард албан хаагчдад 2 хоногийн хоолны мөнгийг илүү бодож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай заалттай нийцэхгүй байна.

Эрсдэл. Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох.

2.8.1.2 Илрүүлэлт. Балансын данстай холбоотой асуудал

Ажлаас чөлөөлөгдсөн ажилтны ээлжийн амралтын тооцоо хийгээгүй.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 15 дахь заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл. Зардал буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 3 арга хэмжээнд зориулан 2018 онд 1,022,407.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,022,407 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт. Тус байгууллагын зарим албан хаагчид сарын эхэнд тухайн сарын сүүл цалин болон дараа сарын урьдчилгааг бодуулж авсан байна. /11 албан хаагч 9.7 сая төгрөг/

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1 дэх заалт *“ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”* гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл. Тухайн сард ажиллаагүй хоногийн зөрүү зэргээс хамааран цалин илүү, дутуу бодогдох, суутгахгүй орхих.

3.1.3 Өгсөн зөвлөмж. Сард 2 удаа буюу сарын эхэнд болон сүүлд цалин бодож олгож байгаа учир ажиллаагүй сарын цалинг урьдчилж бодож олгохгүй байх, дараа сарын цалингийн урьдчилгааг олгохгүй байх.

3.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.2.1 Илрүүлэлт Гэрэл цахилгааны төлбөрийг сар бүр тогтмол 331.3 мянган төгрөгөөр шилжүүлдэг. Тухайн сарын нэхэмжилсэн дүнгээр шилжүүлдэггүй. 1-12 сар хүртэлх шилжүүлсэн дүнгээс 612.4 мянган төгрөгийн илүү төлөлттэй байсан ч БЗӨБЦТС ТӨХК 2018 оны 12 сарын 27-ны өдөр 612.4 мянган төгрөгт тааруулж нэхэмжлэх бичиж хаасан. 12 сарын нэхэмжлэхийн дүн бусад сарынхаас 3 дахин их дүнтэй байгаа нь анхаарал татаж байна. Мөн гэрэл цахилгааны 2, 6, 12 сарын нэхэмжлэх харилцахын баримтад байхгүй байсан.

Цэвэр бохир усны төлбөрийг сар бүр 237.8 мянган төгрөгөөр шилжүүлдэг. Тухайн сарын нэхэмжилсэн дүнгээр шилжүүлдэггүй. Мөн түлш халаалтын зардлаас 2,849.1 мянган төгрөгийг ус алдсаны төлбөрт шилжүүлсэн. Чандмань-Илч ХХК 2017 оны 12 сарын 28-ны өдөр ус алдсаны төлбөр 3,542.3 мянган төгрөгт тааруулж нэхэмжлэх бичиж хаасан. Нягтлан бодогч 9 сард ус алдсан гэсэн тайлбар өгсөн боловч нотлох боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл. Өр, авлага үүсэх, сарын мэдээ, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж. Гэрэл цахилгаан, цэвэр бохир усны төлбөрийг шилжүүлэхдээ нэхэмжлэхийн дүнгээр шилжүүлж байх. Аккурэль сууриар тайлан гаргах.

3.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.3.1 Илрүүлэлт Урсгал засварын зардлаас 1.5 сая төгрөгийн “Touch screen” тоног төхөөрөмж худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын урсгал засварын зардал *“байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, байгууламжид урсгал засвар хийхтэй холбогдон гарсан зардал /засвар үйлчилгээний материал авах, засвар үйлчилгээний хөлс гэх мэт/-ыг энэ ангилалд бүртгэнэ. Мөн байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээтэй холбоотойгоор гарах зардлыг энэ ангилалд бүртгэнэ”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл. Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, үнэн зөв иж бүрэн байх аудитын батламж мэдэгдлийг хангахгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж. Урсгал засварын зардлаас тоног төхөөрөмж худалдан авахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,791,277.06	4,769,390.00
33	АВЛАГА	2,486,787.06	00.00
335	Бусад авлага	2,486,787.06	00.00
3351	Байгууллагаас авах авлага	2,486,787.06	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,304,490.00	4,769,390.00
354	Хангамжийн материал	6,304,490.00	4,769,390.00
35420	Аж ахуйн материал	5,767,650.00	4,232,550.00
35470	Бусад хангамжийн материал	536,840.00	536,840.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	976,792,592.16	1,072,821,828.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	976,792,592.16	1,072,821,828.47
392	Биет хөрөнгө	976,579,466.92	1,022,285,161.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	969,652,877.00	859,623,545.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-203,184,143.57	-630,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,675,000.00	115,675,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-82,562,500.20	-95,946,850.21
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	172,438,746.01	181,227,636.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91,572,931.44	-104,376,105.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,160,059.60	101,008,859.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,143,246.78	-35,809,974.18
39209	Зам, гүүрийн байгууламж	00.00	1,105,950.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,593,338.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-26,477,731.70	00.00
39217	Ном	00.00	407,100.00
393	Биет бус хөрөнгө	213,125.24	50,536,666.80
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-611,874.76	-733,333.20
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	50,445,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	985,583,869.22	1,077,591,218.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	485,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	485,000.00	00.00
413	Өглөг	485,000.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	485000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	985,098,869.22	1,077,591,218.47
51	Засгийн газрын хувь оролцоо	985,098,869.22	1,077,591,218.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	346,112,624.46	396,557,624.46
51101	Өмч: - төрийн	346,112,624.46	396,557,624.46
512	Хуримтлагдсан үр дүн	183,578,718.76	118,435,321.09
51210	Өмнөх үеийн үр дүн	183,578,718.76	183,578,718.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-65,143,397.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	455,407,526.00	562,598,272.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	985,583,869.22	1,077,591,218.47

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,026,894,103.10	1,031,209,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,705,403.10	8,802,150.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,705,403.10	8,802,150.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,705,403.10	8,802,150.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,705,403.10	8,802,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,017,188,700.00	1,022,407,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,017,188,700.00	1,022,407,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,017,188,700.00	1,022,407,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,089,535,711.83	1,074,677,233.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,089,535,711.83	1,074,677,233.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,044,979,811.83	1,074,677,233.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	780,107,600.00	787,167,000.00
210101	Үндсэн цалин	739,235,600.00	609,250,000.00
210102	Нэмэгдэл	00.00	138,150,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,358,400.00	27,205,000.00
210104	Урамшуулал	8,513,600.00	12,562,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,649,500.00	94,518,200.00
210201	Тэтгэврийн даатгал	63,260,300.00	63,732,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,678,200.00	7,696,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,847,300.00	6,157,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,169,100.00	1,539,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,694,600.00	15,393,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,795,412.94	29,768,987.06
210301	Гэрэл, цахилгаан	3,976,000.00	3,976,000.00
210302	Түлш, халаалт	20,819,412.94	22,939,787.06
210303	Цэвэр, бохир ус	00.00	2,853,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,541,500.00	55,580,760.00
210401	Бичиг хэрэг	12,484,045.00	15,077,700.00
210402	Тээвэр, шатахуун	17,417,300.00	24,948,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,342,155.00	8,446,700.00
210404	Ном, хэвлэл	00.00	199,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,058,000.00	6,667,860.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,492,000.00	24,754,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,492,000.00	3,224,000.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	21,530,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,022,900.00	13,284,300.00
210702	Дотоод албан томилолт	9,022,900.00	13,284,300.00

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,232,700.00	5,232,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,214,700.00	3,214,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,496,000.00	1,496,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	462,000.00	462,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,338,198.89	63,571,286.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	7,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,838,198.89	56,571,286.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,555,900.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,555,900.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,455,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,100,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-62,641,608.73</u>	<u>-43,467,483.68</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,800,870.64	21,675,913.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,800,870.64	163,225.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	21,512,688.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-16,800,870.64	-21,675,913.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-79,442,479.37</u>	<u>-65,143,397.67</u>

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,021,713,597.00	1,026,805,894.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	942,134.00	1,246,346.00
120	Нийтлэг татварын бус орлого	942,134.00	1,246,346.00
120009	Бусад орлого	942,134.00	1,246,346.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,020,771,463.00	1,025,559,548.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,017,188,700.00	1,022,407,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,017,188,700.00	1,022,407,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,582,763.00	3,151,948.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,582,763.00	3,151,948.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,016,713,597.00	1,018,426,594.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,016,713,597.00	1,018,426,594.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	968,574,934.00	1,015,274,646.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	779,622,600.00	787,652,000.00
210101	Үндсэн цалин	738,750,600.00	609,735,000.00
210102	Нэмэгдэл	00.00	138,150,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,358,400.00	27,205,000.00
210104	Урамшуулал	8,513,600.00	12,562,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,649,500.00	94,518,200.00
210201	Тэтгэврийн даатгал	55,464,600.00	63,732,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,237,000.00	7,696,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,796,200.00	6,157,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,559,200.00	1,539,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,592,500.00	15,393,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,282,200.00	27,282,200.00
210301	Гэрэл, цахилгаан	3,976,000.00	3,976,000.00
210302	Түлш, халаалт	20,453,000.00	20,453,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,853,200.00	2,853,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,522,900.00	53,255,900.00
210401	Бичиг хэрэг	12,418,900.00	14,902,700.00
210402	Тээвэр, шатахуун	17,417,300.00	24,948,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,396,700.00	8,464,700.00
210404	Ном, хэвлэл	00.00	199,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,050,000.00	4,500,000.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	25,021,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	3,491,000.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	21,530,000.00
2107	Томилот, зочны зардал	9,022,900.00	13,284,300.00
210702	Дотоод албан томилот	9,022,900.00	13,284,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,232,700.00	5,232,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,214,700.00	3,214,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,496,000.00	1,496,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	462,000.00	462,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,442,134.00	8,228,346.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	942,134.00	1,228,346.00

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	7,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,138,663.00	3,151,948.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,138,663.00	3,151,948.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,582,763.00	3,151,948.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,455,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,100,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,000,000.00</u>	<u>8,379,300.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,000,000.00	8,379,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	8,379,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	8,379,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.00	8,379,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,000,000.00</u>	<u>-8,379,300.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,112,624.46	455,407,526.00	210,935,198.13	1,012,455,348.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,112,624.46	455,407,526.00	210,935,198.13	1,012,455,348.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	114,486,674.53	114,486,674.53
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,112,624.46	455,407,526.00	183,578,718.76	985,098,869.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,112,624.46	455,407,526.00	183,578,718.76	985,098,869.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	107,190,746.92	00.00	107,190,746.92
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	50,445,000.00	00.00	-65,143,397.67	-14,698,397.67
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,557,624.46	562,598,272.92	118,435,321.09	1,077,591,218.47

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,022,407,600.00	1,022,407,600.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,022,407,600.00	1,022,407,600.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,022,407,600.00	1,022,407,600.00	0.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	787,652,000.00	787,652,000.00	0.00
210101	Үндсэн цалин	609,735,000.00	609,735,000.00	0.00
210102	Нэмэгдэл	138,150,000.00	138,150,000.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,205,000.00	27,205,000.00	0.00
210104	Урамшуулал	12,562,000.00	12,562,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,518,200.00	94,518,200.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал	63,732,200.00	63,732,200.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,696,500.00	7,696,500.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,157,200.00	6,157,200.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,539,300.00	1,539,300.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,393,000.00	15,393,000.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,282,200.00	27,282,200.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	3,976,000.00	3,976,000.00	0.00
210302	Түлш, халаалт	20,453,000.00	20,453,000.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	2,853,200.00	2,853,200.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,638,200.00	53,638,200.00	0.00
210401	Бичиг хэрэг	14,902,700.00	14,902,700.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	24,948,800.00	24,948,800.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,446,700.00	8,446,700.00	0.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	600,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	4,500,000.00	0.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,000,000.00	33,000,000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	23,000,000.00	23,000,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	13,284,300.00	13,284,300.00	0.00
210702	Дотоод албан томилолт	13,284,300.00	13,284,300.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,232,700.00	5,232,700.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,214,700.00	3,214,700.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,496,000.00	1,496,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	462,000.00	462,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7000000.00	7000000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	7,000,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,022,407,600.00	1,022,407,600.00	0.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,022,407,600.00	1,022,407,600.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,022,407,600.00	1,022,407,600.00	0.00

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	05.00	05.00	0.00
610001	Төсвийн байгууллага	05.00	05.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	39.00	1.00
620001	Удирдах ажилтан	05.00	05.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	29.00	1.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	00.00	00.00	0.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	00.00	00.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	40.00	39.00	1.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	17.00	16.00	1.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12.00	12.00	0.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	00.00	00.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	0.00